



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 319

Улаанбаатар хот

“Комбинат” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2018.оны “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ыг батлах тухай 245 дугаар тогтоолын хавсралтын 7.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Комбинат” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл сунгасугай.
2. Цаашид тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлтийг хууль тогтоомжид заасан хугацаанд ирүүлэх, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Комбинат” ХЗХ /Д.Шархүү/-нд анхааруулсугай.
3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтад холбогдох тэмдэглэгээг 21 хоногийн дотор хийлгэхийг “Комбинат” ХЗХ /Д.Шархүү/-нд үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

• 151800000759